



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ 2010 оны 10  
дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хот Дугаар 471 Боловсролын тухай хуулийн 21  
дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь: 1."Ерөнхий боловсролын  
сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай. 2. Энэхүү үлгэрчилсэн  
дүрэмд нийцүүлэн сургуулийн дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллахыг өмчийн  
бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай. 3. Энэ  
тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын газар  
(Д.Эрдэнэчимэг)-т даалгасугай. САЙД Ё.ОТГОНБАЯР Улсын бүртгэлд 2010 оны 11 дүгээр  
сарын 19-ний өдрийн 3197 дугаарт бүртгэсэн